



СЕКЮРИТИЗ
ҮЦК

ГАДААД ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

2022.03.21-2022.03.25




ГАДААД ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

2022.03.28-ны after trading session байдлаар

АНУ	Ханш	Өөрчлөлт	7 хоног	1 Сар	Он гарснаас хойш
US30	34,861.24	0.44%	0.60%	4.40%	5.86%
US500	4,543.06	0.51%	1.51%	5.16%	13.00%
NASDAQ	14,169.30	-0.16%	2.19%	4.89%	9.87%
Европ		Өөрчлөлт	7 хоног	1 Сар	Он гарснаас хойш
GB100	7,483.00	0.21%	1.06%	0.34%	11.02%
DE40	14,413.00	0.22%	-0.74%	-1.07%	-3.00%
FR40	6,554.00	-0.03%	-1.01%	-1.58%	9.43%
IT40	24,559.00	0.64%	1.39%	-3.37%	0.68%
ES35	8,331.00	0.31%	-1.03%	-1.75%	-1.97%
Ази		Өөрчлөлт	7 хоног	1 Сар	Он гарснаас хойш
JP225	27,973.00	-0.65%	4.29%	5.47%	-4.11%
SHANGHAI	3,169.00	-1.30%	-2.67%	-9.23%	-7.82%
CSI 300	4,105.00	-1.66%	-3.67%	-11.20%	-18.72%
SHANGHAI 50	2,906.00	-1.79%	-3.01%	-10.26%	-20.71%
CH50	13,313.32	-1.60%	-3.00%	-10.82%	-22.97%
SENSEX	57,362.00	-0.41%	0.12%	1.98%	17.05%
Эрчим хүч		Өөрчлөлт	7 хоног	1 Сар	Он гарснаас хойш
Газрын тос (Crude Oil)	110.48	-2.94%	0.45%	10.23%	79.43%
Газрын тос (Brent)	117.35	-2.76%	1.46%	11.76%	80.53%
Байгалийн хий	5.6080	0.65%	14.47%	22.65%	111.42%
Шатахуун	3.4061	-1.82%	0.99%	10.24%	70.65%
Нүүрс	327.15	0.15%	-2.20%	19.18%	248.22%
Түүхий эд		Өөрчлөлт	7 хоног	1 Сар	Он гарснаас хойш
Алт	1,948.07	-0.48%	0.63%	0.25%	13.79%
Мөнгө	25.21	-1.15%	0.12%	-0.56%	2.25%
Зэс	4.6350	-1.06%	-1.38%	1.09%	14.72%
Бонд /10 жил/	Өгөөж	Өөрчлөлт	7 хоног	1 Сар	Он гарснаас хойш
АНУ	2.4787	0.0092	0.18%	0.76%	0.76%
Англи	1.6900	0.0420	0.12%	0.23%	0.96%
Швейцар	0.5640	0.0480	0.17%	0.30%	0.93%
Испани	1.4570	0.0013	0.05%	0.61%	1.14%
Португали	1.3250	0.0012	0.05%	0.29%	1.14%

Эх сурвалж: Trading economics



Эх сурвалж: Business Insider

ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ


АНУ

Бодлогын хүү юунаас болж өсөж байгаа ба цаашид өссөөр байх уу?

Өндөр инфляцын түвшин нь бодлогын хүүг өсгөх гол хүчин зүйл болж байна.

10 жилийн хугацаатай засгийн газрын үнэт цаасны өгөөж 3-р сард 60 гаруй суурь пунктээр (0.60%) өссөн, өнгөрсөн 7 хоногт 30 гаруй суурь пунктээр (0.30%) өссөн нь 2019 оны 5-р сараас хойших хамгийн дээд түвшинд хүрсэн.

Инфляц сүүлийн 40 жилийн дээд цэгтээ хүрснээр ХНС өнгөрсөн 7 хоногт хэрэглээний үнийн өсөлтийг сааруулах тууштай чанга мөнгөний бодлого баримтална гэсэн нь засгийн газрын үнэт цаасны өгөөжийг ингэж огцом өсөхөд нөлөөлсөн байна.



2 жилийн хугацаатай засгийн газрын үнэт цаасны өгөөж 3-р сард 0.75%-иар, он гарснаас хойш 3 дахин өссөн нь засгийн газрын үнэт цаасны өгөөж энэ жил нэмж олон удаа өсөж болзошгүйг илтгэж байна. Шинжээчдийн үзэж байгаагаар богино хугацаатай үнэт цааснаас гадна урт хугацаатай, жишээлбэл 10 жилийн хугацаатай үнэт цаасны өгөөж мөн өснө гэж харцгааж байна.

Учир нь ХНС 2020 оноос хойш 4 их наяд доллар бүхий нийт хөрөнгөө 9 их наяд доллар болтол үнэт цаас авахад зарцуулсан тул энэ жил тэр их үнэт цаасаа эргүүлэн зарахад үнэт цаасны өгөөжийг ихээхэн өсгөх төлөвтэй байна.

Эх сурвалж: www.edwardjones.com

ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ


Англи

Английн инфляци сүүлийн 30 жилийн дээд хэмжээнд хүрчээ

Англид эрчим хүчний үнэ өссөнтэй холбоотой хэрэглээний үнийн индекс энэ 2-р сард өнгөрсөн жилийн мөн үеийнхээс 6.2%-иар өссөн байна. Өсөлтийн трендийг харахад шинжээчдийн үзэж байгаагаар хэрэглээний үнийн индекс энэ жил хамгийн ихдээ 8% хүрч, 2022 ондоо дунджаар 6.5% байхаар тооцоолжээ.

Инфляцын түвшин ингэж хурдтай өсөж байгаа энэ үед Английн Төв банк, бодлогын хүүг энэ жилдээ 2 удаа өсгөж, 2022 оны эцэс гэхэд бодлогын хүүг 1.5% болгох байх гэсэн хүлээлттэй байна.

Английн инфляц ба бодлогын хүүгийн түвшин



Өнгөрсөн 7 хоногт Английн үйлдвэрлэлийн индекс (PMI)-ийн мэдээ гарсан нь Орос-Украины дайн тухайн улсын үйлдвэрлэл болон үйлчилгээний салбарт хэр нөлөөлснийг харуулсан. Английн үйлдвэрлэлийн индекс таамагласнаас илүү унаж 55.5 хүрч, харин үйлчилгээний индекс таамагласнаас илүү өсөж 61 хүрсэн нь тус улсын үйлдвэрлэл илүү хүнд цохилтод орсныг илэрхийлж байна.

Эх сурвалж: www.edwardjones.com

ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

БНХАУ

БНХАУ-ын үйлдвэрлэл болон үйлчилгээний индексийн мэдээ

БНХАУ-ын үйлдвэрлэл болон үйлчилгээний индексийн мэдээ энэ Пүрэв гарагт гарах ба тус мэдээгээр БНХАУ-ын үзүүлэлт буурсан гарах хүлээлттэй байна. 2022 оны эхээр тухайн улсын хэрэглээний, хөрөнгө оруулалтын, үйлдвэрлэлийн салбарууд таамаглаж байснаас илүү үзүүлэлттэй байсан боловч Ковид-гүй байх бодлогын улмаас энэхүү сайн үзүүлэлт муудаж магадгүй байна.

Мөн дээрээс нь тус улсын үл хөдлөх хөрөнгийн салбарын уналт болон Орос-Украины дайны нөхцөл байдал эдийн засагт сөрөг үр дагавар үзүүлэн үйлчилгээ болон үйлдвэрлэлийн индексийг 3-р сард 50.6-аас 50.0 болон буурна гэж шинжээчид таамаглаж байна.



Эх сурвалж: Wells Fargo


ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

Европ

Европын хэрэглээний үнийн индексийн мэдээ

Ирэх Баасан гарагт Европ даяарх 3-р сарын хэрэглээний үнийн индексийн мэдээ гарна. Шинжээчдийн үзэж байгаагаар эрчим хүчний үнэ өмнөх жилийн мөн үеэс 31.7% өссөн нь 2-р сарын байдлаар инфляцын түвшинг аль хэдий нь түүхэн дээд цэг байсан 5.9%-иас цааш нь нэмж өсгөнө гэж харж байна.

Европ даяарх инфляцын түвшин



Шинжээчдийн үзэж байгаагаар Европ даяарх хэрэглээний үнийн индексийг 2022 онд дунджаар 5.2%-ийн өсөлттэй, хамгийн ихдээ 6.5%-ийн өсөлттэй тулгарах болов уу гэж таамаглаж байна. Европын Төв банк энэ сард мөнгөний бодлогын хүрээнд бондын худалдан авалтаа сааруулахаа мэдэгдсэн.

Эх сурвалж: Wells Fargo